



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Төмөрбаатарын АЮУРСАЙХАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-18-83, Факс: 32-70-16
E-mail: ayursaikhan@parliament.mn
http://www.parliament.mn

2016.12.28 № 6931

танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Уг тогтоолын төслийг Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, төслийн танилцуулга, төрийн бус байгууллагын санал болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН

ГИШҮҮН



Т. АЮУРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Төмөрбаатарын АЮУРСАЙХАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-18-83, Факс: 32-70-16
E-mail: ayursaikhan@parliament.mn
http://www.parliament.mn

2015. 11-18 № 5108

танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дагуу "Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.


Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Тогтоолын төсөл, төслийн танилцуулга, төрийн бус байгууллагын санал болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Т.АЮУРСАЙХАН



**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ТАЛААР АВАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл хийх болсон үндэслэл, шаардлага

Үндэсний статистикийн хорооноос гаргасан ажиллах хүчний судалгааны 2016 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 1263.2 мянга, үүн дотроо ажилгүй иргэд 118.8 мянга байна.

Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 24.7 (2.2%) мянгаар, ажилгүй иргэд 43.1 (56.9%) мянгаар, эдийн засгийн идэвхгүй хүн ам 35.2 (4.7%) мянгаар өссөн байна.

Судалгаанаас харахад 15-24 насны залуусын дунд ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлтийн асуудал ноцтой хүндэрч байгаа нь харагдаж байна.

Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс ажлын байрыг нэмэгдүүлэх, бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр тусгайлсан бодлого боловсруулан ажиллаж ирсэн ч өнөөдрийг хүртэл хөрсөн дээр буулгүй, үр дүнгээ төдийлөн сайн өгөлгүй өдийг хүрлээ.

Улсын хэмжээнд тэр тусмаа орон нутгийн хэмжээнд ажлын байр хомстож, ажилгүйдэл нэмэгдэхийн хэрээр тухайн иргэд өрхийн амьжиргаагаа дэмжих зорилгоор хувиараа ашигт малтмал олборлох, бичил уурхай эрхлэх тохиолдол жил бүр нэмэгдсээр байна.

Уул уурхайн салбарын судлаачид болон эдийн засагчид Монгол Улсад бичил уурхай үүссэн шалтгааныг шилжилтийн үеийн үйл явц, ажилгүйдэл, байгалийн гамшиг, зуд, ашигт малтмалын нөөцийн орд, илэрцийн геологийн өвөрмөц тогтоц, уул уурхайн олборлох аж ахуйн нэгжүүдийн хариуцлагагүй үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлүүдтэй холбон үзэж тайлбарладаг. Швейцарын хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай төсөл”-с хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаануудыг нэгээс дээш сонголт бүхий давхардсан байдлаар хариулт өгсөн үзүүлэлтээс харахад судалгаанд оролцогчдын 76,6 хувь нь орлого олох өөр боломж байхгүй тул амьжиргаагаа залгуулах, 69,3 хувь нь ажлын байргүйгээс, 35,0 хувь нь зуданд малаа алдаж малгүй болсон тул, 24,9 хувь нь хүүхдийн сургалтын төлбөр төлөх зорилгоор гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 71 дүгээр тогтоолоор “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” баталсан ч хэрэгжилт тун хангалтгүй байсаар хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусгавар болсон.

Иймд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдэд бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар тусгай дэд хөтөлбөр нэмж боловсруулах, тэдгээрийн ажил эрхлэлтийн өөр зэрэгцээ хэлбэр, орон нутгийн нөхцөлд тохирсон шинэ ажлын байруудыг бий болгох, мэргэжлийн боловсролын төрөл бүрийн сургалтын тогтолцоог бүрдүүлэх, бичил уурхайн үйл

ажиллагаа төвлөрсөн засаг захиргааны нутаг дэвсгэрт өрхийн болон жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг тусгайлан байгуулах, тэдгээрт бичил уурхай эрхлэгчдэд, ялангуяа уул-геологийн нөхцөл нь хүндэрсэн, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хурцадсан газруудад ажиллаж буй иргэдэд шинээр хөдөлмөр, бичил, жижиг бизнес эрхлэх боломжийг олгох удирдлага зохион байгуулалт, хүртээмжтэй санхүүжилтийн эх үүсвэрээр хангаж ажиллах гэсэн тодорхой зорилтуудын хүрээнд Монгол Улсын Их Хурлын Тогтоолын төслийг боловсруулсан болно.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2 дахь заалт, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.64-т тус тус бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг дэмжих, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” зэрэг ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдэд бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар тусгай дэд хөтөлбөр нэмж боловсруулах, ажил эрхлэлтийн зэрэгцээ хэлбэр, орон нутгийн нөхцөлд тохирсон ажлын байруудыг шинээр бий болгох, мэргэжлийн боловсролын төрөл бүрийн сургалтын тогтолцоог бүрдүүлэх, бичил уурхай эрхлэгчид тэр дундаа уул-геологийн нөхцөл нь хүндэрсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал хурцадсан газруудад бичил уурхай эрхэлж буй иргэдэд ажил хөдөлмөр эрхлэх, шинээр бичил, жижиг бизнес эхлүүлэх боломжийг олгох талаар төрийн зүгээс удирдлага зохион байгуулалтаар хангах, зохих санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, тухайн иргэдэд мэргэжил эзэмшүүлэх богино хугацааны болон давтан сургалт явуулах, дадлагажуулах, сургалтын болон дадлагажуулах хугацаанд тухайн иргэдэд түр хугацааны тэтгэлэг олгох талаарх харилцааг зохицуулна.

Ингэхдээ шаардагдах төсвийг гадаадын улс орнууд болон олон улсын байгууллагуудтай тусгайлсан төсөл, хөтөлбөр боловсруулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар бүрдүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, бичил уурхай эрхлэгч иргэдийн нийгмийн болон эдийн засгийн баталгааг сайжруулна.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь нийт 3 зүйл, 3 заалтаас бүрдсэн бөгөөд холбогдох хуулиудад нийцсэн болно.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн дагаврын талаар.

Энэхүү тогтоолын төсөл батлагдан бичил уурхай эрхэлж буй иргэдийн талаар төрийн зүгээс тусгайлсан бодлоготой болж, дэд хөтөлбөрүүд шинээр нэмж боловсруулагдах чухал ач холбогдолтой юм.

Тухайн бодлого, дэд хөтөлбөрүүд хэрэгжсэнээр орон нутгийн нөхцөлд тохирсон ажлын байрууд шинээр бий болж, бичил уурхай эрхлэгч иргэдийн ажил эрхлэлтийн өөр зэрэгцээ хэлбэрүүд бий болохоос гадна мэргэжлийн боловсрол олгох богино хугацааны болон давтан сургалт явуулах, дадлагажуулах хугацаанд тэдгээр иргэдэд түр хугацааны тэтгэлэг олгох замаар өрхийн амьжиргааг нь дэмжих боломж бүрдэнэ.

Улмаар тухайн орон нутагт бичил буюу жижиг бизнес эрхлэгчдийг шинээр бий болгох замаар орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ болон мөнгөний эргэлт нэмэгдэж, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний төлбөр, татвар, хураамжийг бүрдүүлэх зэрэг бодит үр дүн гарна.

Дөрөв. Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах талаар.

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудтай нийцэж байгаа болно.

ТОГТООЛЫН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ:
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Т.АЮУРСАЙХАН

**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ТАЛААР АВАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол улсын эдийн засгийг 2016-2020 онд сэргээх, эрчимжүүлэх бодлогын хүрээнд бичил уурхай эрхлэгч иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх.

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдэд бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар тусгайлсан дэд хөтөлбөр нэмж боловсруулах, тухайн иргэдэд ажил эрхлэлтийн өөр зэрэгцээ хэлбэрүүдийг шинээр бий болгох.

Бичил уурхай эрхлэгч иргэдийг мэргэжлийн боловсролын богино болон давтан сургалтанд хамруулах, дадлагажуулах, тухайн хугацаанд түр хугацааны тэтгэлэг олгох замаар өрхийн амьжиргааг нь дэмжих, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэн бичил болон жижиг бизнес эрхлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай санхүүжилтийг гадаадын улс орнууд болон олон улсын байгууллагуудтай тусгайлсан төсөл, хөтөлбөр боловсруулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар бүрдүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох замаар тогтоолын хэрэгжилтийг хангах.

Бичил уурхай эрхлэлт төвлөрсөн орон нутагт өрхийн болон жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг тусгайлан байгуулах, уул-геологийн асуудал нь хүндэрсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал хурцадсан газар бичил уурхай эрхэлж буй иргэдийг өөр ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг нэн түрүүнд бүрдүүлэх.

Бичил уурхай эрхэлж буй иргэдэд бичил, жижиг бизнес эрхлэх боломжийг олгох талаар төрөөс удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах.

Гадаадын улс орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр тусгайлсан төсөл, хөтөлбөр боловсруулж, бичил уурхай эрхлэгч иргэдийн нийгмийн болон эдийн засгийн баталгааг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгаж, үүрэг, даалгавар өгөхөөр зохицуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь нийт 3 зүйл, 3 заалтаас бүрдсэн бөгөөд холбогдох хуулиудад нийцсэн болно.

Тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлж санал, дүгнэлтийг авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдсанчлан тогтоолын төслийн нэр томъёог хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан болно.

**ТОГТООЛЫН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ:
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Т.АЮУРСАЙХАН**

Төсөл.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны дугаар
сарын - ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:
1/Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдэд бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар тусгай дэд хөтөлбөр шинээр нэмж боловсруулах, тэдгээрийн ажил эрхлэлтийн өөр зэрэгцээ хэлбэрүүдийг бий болгох, мэргэжлийн боловсролын төрөл бүрийн сургалт, орон нутгийн нөхцөлд тохирсон шинэ ажлын байрууд бий болгох талаар тусгаж хэрэгжүүлэх;
2/Бичил уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн засаг захиргааны нутаг дэвсгэрт өрхийн (бичил) болон жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг тусгайлан байгуулах, тэдгээрт бичил уурхай эрхлэгчдэд, ялангуяа уул-геологийн нөхцөл нь хүндэрсэн, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хурцадсан газруудад ажиллаж буй иргэдэд шинээр хөдөлмөр, бичил, жижиг бизнес эрхлэх боломжийг олгох удирдлага-зохион байгуулалт, хүртээмжтэй санхүүжилтийн эх үүсвэрээр хангаж ажиллах;
3/Бичил уурхай эрхлэгч иргэдэд ажил, мэргэжлийн өөр төрлийн, богино хугацааны сургалт, давтан сургалт явуулах, дадлагажуулах хугацаанд тэдгээрт түр хугацааны тэтгэлэг олгох, үр дүнг нь харгалзсан санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх;
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхдээ шаардагдах хөрөнгийг олон улсын байгууллагууд, гадаад улс орнуудтай тусгай төсөл, хөтөлбөр боловсруулж хамтран ажиллах чиглэлээр бүрдүүлэн, санхүүжүүлж ажиллахыг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2016 он 10 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар ... хэрг /1781


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.АЮУРСАЙХАН ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн "Гар аргаар ашигт малтмал албан бусаар олборлож буй иргэдийн талаар авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

002490

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханы санаачлан боловсруулсан “Гар аргаар ашигт малтмал албан бусаар олборлож буй иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханы санаачлан боловсруулсан “Гар аргаар ашигт малтмал албан бусаар олборлож буй иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. тогтоолын төсөлд заасан “гар аргаар ашигт малтмал албан бусаар олборлож буй иргэд” гэсэн нэр томъёо нь Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална” гэж, мөн хуулийн 4.1.23-т ““бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл ордын талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-т заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг” гэж, мөн хуулийн 7.3-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байх тул хуульд нийцүүлэх шаардлагатай;

2. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2 дахь заалт, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.64-т тус тус бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг дэмжих, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан болно.

Түүнчлэн тогтоолын төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн боловсролын сургалтын талаар авахаар заасан арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулах боломжтой байна.

3. Төсвийн тухай хуулийн 6.2.4-т Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байхаар хуульчилсан тул тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, эх үүсвэрийг тодорхой болгож, төсөвт үзүүлэх нөлөөллийн дүгнэлтийг гаргах нь зүйтэй.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.АЮУРСАЙХАН ТАНАА

**МОНГОЛЫН БИЧИЛ УУРХАЙН
НЭГДСЭН ДЭЭВЭР ХОЛБОО**

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
2-р хороо Сөүлийн гудамж 45/2 Ханну төв
603 тоот Утас: 99006429, 88300-442
E-mail: info@bichiluurhai.mn

2016. 11. 07 № 105

Танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо(МБУНДХ) нь 2013 оны 5-р сарын 2-ны өдөр байгуулагдсан. Одоогийн байдлаар 13 аймгийн 38 сумын 62 ТББ-ын 6,200 гаруй бичил уурхайчдыг эгнээндээ нэгтгэж гишүүдийнхээ эрхийг хамгаалах, тэднийг чадавхижуулах, тэдний дуу хоолойг төр засагт хүргэх түүнчлэн албан бусаар, хувиараа ашигт малтмал олборлогч (ХАМО) иргэдийг зохион байгуулалтанд оруулах, үйл ажиллагааг нь хуулийн хүрээнд албажуулах чиглэлээр 3дахь жилдээ ажиллаж байна.

МБУНДХ нь бичил уурхайчдын бодит хэрэгцээ, улс орны нийтлэг эрх ашигт тулгуурлан ХАМО иргэдийг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулалтанд оруулах аюул осолгүй, байгальд хал багатай, үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт зохион байгуулдаг. Мөн түүнчлэн бичил уурхайчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах, байгальд хал багатай технологи ашиглах талаар ухуулга, сурталчилгаа хийж улмаар өөр орлогын эх үүсвэртэй болгоход чиглэсэн бизнесийн чадвар олгох, төсөл бичих сургалтуудыг зохион байгуулж, мэргэжил эзэмшүүлэхэд зуучлах зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Дээрх төрлийн сургалт, сурталчилгаанд 20 аймгийн 105 сумын зорилтот бүлгийн 15,000 орчим хүнийг хамруулсан бөгөөд тэднээс 6,000 орчим нь хуулийн дагуу зохион байгуулалтанд орсон, тодорхой хувь нь олон талаар чадавхижиж, жижиг төсөл хэрэгжүүлэн өөр ажлын байранд шилжиж, орлогын өөр эх үүсвэртэй болж амжиргаа нь дээшилсэн байна.

МБУНДХ нь уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Швейцарын хөгжлийн агентлагын Тогтвортой бичил уурхай төсөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын хөгжлийн байгууллагуудтай амжилттай хамтран ажиллаж байна.

Таны санаачлан боловсруулсан “Гар аргаар ашигт малтмал албан бусаар олборлож буй иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын Тогтоолын төсөлтэй бид танилцлаа. Энэ тогтоолын төсөл батлагдвал төрийн бодлогын түвшинд бичил

уурхайд тулгамдаж байгаа олон асуудлыг зохицуулах, шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болно гэдэгт бид итгэлтэй байна.

Иймд МБУНДХ нь албан бусаар хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэд болон бичил уурхайчдад чиглэсэн Таны санал санаачлагыг дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлж байна. Мөн МБУНДХ-ны төлөөллүүд тантай биечлэн уулзах хүсэлтэй байгааг минь хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАЯРМАА